ОЮУН УХААНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД БОЛОВСРОЛ ОЛГОХ ТОГТОЛЦОО, СТАНДАРТ, ТӨСӨВ САНХҮҮЖИЛТ, БАГШЛАХ БОЛОВСОН ХҮЧНИЙ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО (Лавлагаа - Мэдээлэл)

Ц. Товуусүрэн, Р. Хатанбаатар, А. Пагма, Ч. Базар (Ph.D), Б. Дуламсүрэн, Б. Мөнхцэцэг

ГАРЧИГ

1. Оюун ухааны хомсдлын тухай ерөнхий ойлголт
2. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших асуудлын эрх зүйн зохицуулалт
3. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох тогтолцоо, түүний шатлал
4. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалт, боловсролд баримтлаж байгаа стандарт
5. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын байгууллагын багшлах боловсон хүчин, төрөөс баримтлаж байгаа бодлого
6. Хөдөө орон нутагт амьдардаг оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролд хамрагддаг эсэх
7. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суррч боловсроход улсаас зарцуулж буй төсөв
8. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш, сурган хүмүүжүүлэгч нарын цалин, орлого

* * *

1. Оюун ухааны хомсдлын тухай ерөнхий ойлголт

Оюун ухааны хомсдол (mental retardation-англи, олигофрения-грекээр oligos- бага, phereni-ухаан) нь “сэтгэхүйн, юуны түрүүнд сэтгэн бодох үйл ажиллагааны түвшний эргэшгүй, тогтонги дутуу хөгжил бөгөөд төрөлхийн буюу тархины эд эсийн сэргэшгүй согог бүхий олдмол чанартай байж болно. Оюун ухааны хувьд бүрэн бус байхаас гадна сэтгэл хөдлөл, хүсэл зориг, хэл яриа, хөдөлгөөний эх үүсвэрүүдийн хүрээний эмгэгүүд хамаардаг.

17-18-р зуунд оюуны хомсдолтой хүүхдийн сурган, сэтгэл судлалын шинжлэх ухааны үүссэн нь сэтгэц гэм судлалын шинжлэх ухаанд, оюуны хомсдолыг сэтгэл мэдрэлийн өвчнөөс ангид үзэхээр болсонтой холбоотой.

Германы эрдэмтэн Эмиль Крепелин анх олигофрени гэсэн нэр томъёог санал болгохдоо сэтгэхүйн согогийн төрмөл хам шинж (синдром) гээд энэ нь ухаан санааны олдмол доройтлоос ялгаатай гэжээ.

Францын материалистуудын үзэл баримтлалын (1789-1793) нөлөөгөөр оюуны хомсдолтой хүмүүст хандах нийгмийн хандлага ихээхэн өөрчлөгдөж эхэлсэн. Ядуу зүдүү, ухаан хомс, ядарсан хүмүүсээ халамжлах нь улсын үүрэг гэж Францын хөрөнгөтний хувьсгалаар тунхагласан ч амьдралд хэрэгжүүлэх боломж олдоогүй. Гэвч энэ үзэл санаа дээрхи хүмүүст хандах нийгмийн шинэ хандлага бүрэлдэн тогтож цаашид хөгжихөд их үүрэг гүйцэтгэсэн байна.

Оюуны хомсдолтой хүнийг сургах талаар анх удаа сурган хүмүүжүүлэгчдээс Ян Амос Коменский/1592-1670/, клиник талаас Филипп Пинель (1745-1826), Жан Эскироль (1772-1840) нар судалж ангилал тогтоожээ. Эскироль оюун ухааны хомсдолыг төрөлхийн, олдмол гэж ялгаад, оюуны хомсдолын хүндэвтэр зэрэглэлийг тэмдэглэсэн “имбецилизм”-гэдэг нэр томъёог гаргасан.

18-р зууны сүүл, 19-р зууны эхээр эмч, багш нар, нийгмийн дунд оюуны хомсдолтой хүнд тусламж арчилгаа үзүүлэх, сургаж хүмүүжүүлэх тусгай байгууллага буй болгох санал дэвшүүлж эхэлсэн боловч, сургаж хүмүүжүүлэх асуудал маш их эргэлзээг төрүүлж, багш нар хүртэл утгагүй, үр дүнгүй зүйл гэж үзэж эсэргүүцэж байжээ.

Швейцарын нэрт сурган хүмүүжүүлэгч Песталоцци (1746-1827), оюуны хөнгөн хэлбэрийн хомсдолтой хүнийг зайлшгүй сургаж хүмүүжүүлэх шаардлагатай гэж үзээд, оюуны хомсдолтой хүүхдэд тохирсон сургалт, сурганы талын дидактикийн материал хэрэглэх, оюуны хөдөлмөрийг биеийн хөдөлмөртэй хослуулах, сургалтыг амьдралтай холбох гэх мэт тусгай сургалтын зарчмуудыг дэвшүүлсэн. Песталоццийн энэхүү үзэл санаа дэмжлэг аваагүй ба хэрэгжих нийгэм эдийн засгийн нөхцөл нь ч бүрэлдээгүй байв. Францын эрдэмтэн Эдуард Сеген (1812 - 1880) оюуны хомсдолтой хүүхдийн тусгай байгууллагыг нээж, 1846 онд хүнд хэлбэрийн оюуны хомсдолтой хүүхэдтэй ажиллах системийг боловсруулж энэ талаар ном гаргажээ.

19-р зууны 2-р хагаст ерөнхий боловсролын сургуулийн дэргэд тусгай анги бүлгүүд нээгдэж багш нарын үүрэг нэмэгдсэн байна. Орос улсад оюуны хомсдолтой хүүхдэд зориулсан тусгай сургууль 1908 онд байгуулагдсан. Манай улсад оюуны хомсдолтой хүүхдэд зориулсан тусгай анги бүлгийг анх 1967 онд 24-р сургуулийн дэргэд байгуулсан ба хожим 25-р тусгай сургууль болон өргөжсөн.

Оюуны хомсдол үүсэх шалтгаан

Оюуны хомсдолыг үүсгэх маш олон янзын хүчин зүйлүүд байдгийг ерөнхийд нь дотоод

буюу төрөлхийн биологийн шалтгаанууд, гадаад буюу бие организм, мэдрэлийн системд хортой нөлөөлсөн шалтгаанууд гэж хуваадаг.

Дотоод шалтгаанд удамшлын нөлөө, хромосомын төрөлхийн гажгууд (Дауны өвчин, ”муурын дууны” хам шинж, Клайнфельтер, Тернерын хам шинжүүд гэх мэт), бодисын солилцооны төрөлхийн гажгууд (фенилкетонурия), үр хөврөл бүрэлдэн тогтох үед эхийн талаас нөлөөлсөн хорт хүчин зүйлүүд орно. Үүнд: Эх жирэмсэн байх үедээ янз бүрийн хортой халдварт өвчнөөр жишээ нь, тэмбүү, цусан хордлого, улаанууд зэрэг өвчнөөр өвчлөх, мөн хортой болон эмийн бодис, архи, хар тамхи хэтрүүлэн хэрэглэх нь урагт хортой нөлөө үзүүлж ургийн хэвийн хөгжлийг гажуудуулдаг байна.

Оюуны хомсдолыг үүсгэх гадаад хүчин зүйлүүдэд эхийн хэвлийд байгаа үр, хөврөл, ураг, төрөх үе болон төрсний дараах 4 хүртэлх насанд хүүхдэд гадна орчноос нөлөөлсөн төрөл бүрийн хурц архаг тархины халдварууд, эх хүүхдийн бие организмын дотоод болон гаднаас авсан хордлогууд, мэдрэлийн систем уураг тархины бэртэл гэмтлүүд, хүрээлэн буй орчны бохирдол, туяаны хордлого орно.

Эцэг эхэд өндөр тун бүхий цацраг идэвхит туяа, хар тугалга, мөнгөн ус зэрэг хортой бодис удаан хугацаагаар нөлөөлж үйлчлэх нь ургийн хөгжилд хортойгоор нөлөөлнө.
Илүү тээлтийн үед уураг тархины хүчилтөрөгчийн дутагдал тархинд цус харвалт үүсгэн улмаар төв мэдрэлийн систем, уураг тархины мэдрэлийн эд эсийг гэмтээнэ. Харин дутуу төрсөн хүүхэд маш эмзэг оюуны хөгжлийн хоцрогдол үүсэх магадлал өндөртэй байна.

Хоол тэжээлийн дутагдлыг ч оюуны хөгжлийн бэрхшээл үүсэхтэй холбон үзэх болсон. Буурай хөгжилтэй орнуудын ард түмэн хоол хүнсний хангамж байнга дутагдалтай байдаг. Судлаачид хоол хүнсний дутагдал, мэдрэлийн систем, уураг тархины дутуу хөгжилд шууд холбоотой байгааг тогтоосон байна.
Хүүхдийн онтогенез (нэгэн биеийн хөгжил буюу төрөхөөс эхлээд өөд болох үе) хөгжлийн ямар үе шат, цаг хугацаанд дээр дурьдсан хортой хүчин зүйлүүд яаж нөлөөлөв гэдэгтэй холбоотойгоор оюуны хомсдлын үүсэх шалтгаан, илрэл янз бүр байдаг. Ийм учраас эдгээр хортой шалтгаанууд нөлөөлсөн цаг хугацаанаас нь хамааруулж гурван бүлэгт хувааж үздэг. Үүнд:

1. Төрөхийн өмнөх үе. Үр хөврөл дөнгөж бүрэлдэн тогтож байгаа жирэмслэлтийн эхний 3 долоо хоногт нөлөөлж буй хорт хүчин зүйлүүд. Жишээ нь согтуу үед үр тогтох, жирэмслэлтээс сэргийлэх эм гэх мэт. Жирэмсний 3-12 дахь долоо хоногт үр хөврөлийн эрхтэн системийн эх үүсвэр тавигдаж байгаа үед буюу цаашид жирэмсний 4 сар хүртэлх хугацааны үр хөврөлийн хөгжих үед нөлөөлсөн хортой хүчин зүйлүүд. Жишээ нь эх жирэмсэн байх үедээ улаанууд өвчнөөр өвдөх Мөн жирэмсэн эх янз бүрийн архаг хүнд өвчин, хордлогоор өвдөх, хүчтэй сэтгэл санааны цохилтонд орох зэрэг орно.
2. Төрөх үе. Энд төрөхтэй холбоотой хүүхдийн тархины гэмтэл, бэртлүүд, цус алдалт, хавчуурга тавьж төрүүлэх гэх мэт
3. Төрсний дараах үе. Төрсний дараа хүүхэд янз бүрийн хурц архаг халдварт өвчнөөр өвдөх, хордлого, тархины гэмтлүүд зэрэг орно.

Ийнхүү дээрхи дурьдсан шалтгаануудаас үүдэлтэй оюуны хомсдолын үед уураг тархи, мэдрэлийн системд бүтэц зохион байгуулалтын мэдэгдэхүйц согог өөрчлөлтүүд гардаг. Жишээ нь, тархины тодорхой хэсэг үгүй болох, эсвэл тархи бүхэлдээ дутуу хөгжих, тархи жижигрэн бичилтэх, нугалаанууд нь хатингаршин багасах, тархи хэт томрох, усан тархитах гэх мэт.

Оюуны хомсдолын ангилал, онцлог

Оюуны хомсдлыг, ДЭМБ-аас боловсруулан, дэлхийн болон манай улсын сэтгэцийн эмгэгийн оношлогооны өнөөгийн практикт мөрдөж байгаа өвчний олон улсын 10-р ангиллаар дарааx хэлбэрт хувааж ангилсан байна. Оюуны хомсдлын ангиллыг хүснэгтээр үзүүлбэл

Хүснэгт 1.

F70-F79 Оюуны хомсдлын ангилал
умственная отсталость, mental retardation (13.132)

Шифр	Монгол хэлээр	Орос хэлээр	Англи хэлээр
F70	Оюуны хөнгөн хомсдол / IQ50-69 /	Легкая умственная отсталость	Mild mental retardation
F71	Оюуны хүндэвтэр хомсдол/IQ 35-49/	Умеренная умственная отсталость	Moderate mental retardation
F72	Оюуны хүнд хомсдол/ IQ 20-34/	Тяжёлая умственная отсталость	Severe mental retardation
F73	Оюуны маш гүнзгий хомсдол /IQ 20-оос бага	Глубокая умственная отсталость	Profound mental retardation
F78	Оюуны хөгжлийн бусад хомсдол	Другой тип умственной отсталости	Other mental retardation
F79	Тодорхойлогдоогүй оюуны хомсдол	Неуточненная умственная отсталость	Unspecified mental retardation

1. Хөнгөн хэлбэр – (IQ түвшин нь 50 - 55 буюу 70 - ын хооронд)

Энэ хэлбэрийн оюуны хомсдолтой хүүхдүүд нь аливаа юмс үзэгдлийн талаар тодорхой хэмжээгээр ойлголттой, эрэгцүүлэн бодох чадвартай, хийсвэр сэтгэхүй сул хөгжсөн, механик цээжлэх ой сайтай, энгийн хийсвэрлэн сэтгэх чадвартай, юмны учир зүйн холбоо агуулга чанарыг дутуу ойлгодог. Мөн аливаа далд утгатай үг, тооны болон шинжлэх ухааны мэргэжлийн нэр томъёо, хийсвэр ухагдахууныг сул эзэмшдэг. Харин өдөр тутмын амьдралд байнга хэрэглэгддэг үг, ойлголт, үзэгдэл юмсын холбоог ойлгоно. Нийгмийн дасан зохицолт харьцангуй сайн байна. Энэ бүлгийн оюуны хомсдолтой хүмүүс тохирсон тусламж авбал бие даан амьдрах чадвартай төдийгүй, орчноос үзүүлэх тодорхой хяналтын дор ажиллаж хөдөлмөрлөх бололцоотой. Ерөнхий боловсролын сургуулийн 4-р ангийн ерөнхий эрдмийн мэдлэгийг эзэмших бүрэн чадвартай. Энэ түвшний оюуны хомсдолтой хүүхдүүд манай улсад хөнгөвчилсөн сургалттай тусгай сургуульд (25,55,63,70) болон тусгай сургууль төгсөгчид нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд сурч ажил хөдөлмөрийн дадал олж авч, улмаар энгийн хөнгөн мэргэжил /мужаан, оёдол, нарийн боов, / эзэмшиж бие даан амьдрах чадвартай болж байна.

2. Дунд хэлбэр- (IQ түвшин нь 35-40, 40-50-ын хооронд)

Энэ хэлбэрийн оюуны хомсдолын үед үгийн нөөц маш хязгаарлагдмал, амьдралын шаардлагын дагуу үүссэн хамгийн энгийн ойр зуурын ярианы хэлтэй, бие даах болон өөртөө үйлчлэх чадвар сул. Ойр зуурын хэрэгцээний механик ойтой, юмыг зөвхөн мэдэрч танин мэдэх чадвартай, анхаарч танин мэдэх чадвараар сул, сэтгэлийн хөдөлгөөн тогтворгүй зэрэг шинжтэй. Хүрээлэн буй орчин юмс үзэгдлийн ойлголт, харьцуулалт, хангалтгүй. Танин мэдэхүйн үйл сул хөгжсөн. Энгийн ойлголт ухагдахууныг л эзэмшинэ. Энэ түвшний хүүхдүүд хүнийг дуурайх замаар хамгийн энгийн үйлдэл хөдөлгөөн, зарим механик ажлыг гүйцэтгэж чадах боловч сурах үйл хүндрэлтэй явагдах ба багшийн болон

насанд хүрэгчдийн байнгын хяналт, тусламжийг шаарддаг.

3. Хүнд хэлбэр –(IQ түвшин нь 20-25, 35-40-ийн хооронд)

Энэ хэлбэрийн оюуны хомсдолтой хүнтэй үгээр харилцаанд орох боломжгүй. Хүний хандсан яриа, түүнд өгч байгаа зааврыг ойлгохгүй. Хүмүүсийн байнгын асаргаа халамжинд байна. Өөрийн хэрэгцээгээ дохио зангаа, тэмдгээр илэрхийлнэ. Оюуны хомсдлын энэ хэлбэр өөр бэрхшээлтэй хавсарсан "Давхар согог"-ийн байдалтай байдгаас гадна гол төлөв хэвтрийн өвчтэй, асрамж сувиллын газарт байдаг. Ийм хүүхдүүд бие эрхтний мэдэгдэхүйц согогтой, аливаа өвчинд амархан өртөмтгий тул амьдрах хугацаа богино.

4. Гүнзгий хэлбэр –(IQ түвшин нь 20-25-ийн хооронд)

Оюуны хомсдлын энэ хэлбэр оюуны хомсдолтой иргэдийн 1-2% ийг эзэлнэ. Нялх байх үедээ 5 мэдэрхүйн үйл ажиллагаа нь маш хангалтгүй хөгжинө. Америкийн сэтгэцийн эмгэг судлалын нийгэмлэг (AAMR)-ийн тодорхойлж байгаагаар оюуны хомсдлыг хөнгөн, хүндэвтэр, хүнд, гүнзгий гэж ангилдаг хэлбэрүүдийн нэршлийг хэрэглэхгүй гэж үзэж байгаа юм байна. Харин " түр зуурын", "тодорхой хугацааны", "урт хугацааны", "бүх талын" гэх мэтээр яг тухайн цаг үед л хэрэгтэй байгаа дэмжлэг туслалцааны нөхцөл байдлаар тухайн эмгэгийн нэршлийг илэрхийлье гэсэн санааг дэвшүүлсэн байна. Оюуны хомсдол, дэмжлэг туслалцаа гэсэн ойлголтууд зайлшгүй харилцан холбоотой асуудал гэдгийг ойлгох хэрэгтэй.

Дээрхи тодорхойлолт, ангиллаас үзэхэд оюуны хомсдолын ерөнхий шинж тэмдэг, оюун ухааны дутуу хөгжил буюу сэтгэцийн хөгжлийн саатал, нийгэмдээ дасан зохицох чадварын алдагдал гэж ойлгож болох юм.

2. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших асуудлын эрх зүйн зохицуулалт

Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг зохицуулсан хууль тогтоомж нь нилээн олон хуулийг хамран зохицуулагдаж байна.

Олон улсын баримт бичгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх тусгагдсан байдал

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенц, 1989он

Энэхүү баримт бичигт эсэн мэнд амьдрах эрх, сурч боловсрох, хөгжих эрх, хамгаалуулах эрх, нийгмийн амьдралд оролцох, мэдээлэл хүртэх эрх зэрэг хүүхдийн эдлэх ёстой суурь эрхүүдийг тунхагласан. Тус Конвенцийн 23 дугаар зүйлд тэдэнд тусгай халамж болон тэгш хандах зарчмыг эрхэмлэх тухай тусгасан.

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох тухай Стандарт дүрэм, 1993он

Нийгмийн, улс төрийн амьдралд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэгш оролцох нөхцөл

боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн засгийн газруудын үйл ажиллагааны хэрэгжилтийг үр дүнтэй болгоход чиглэгдсэн зөвлөмж юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын асуудлаарх олон улсын бага хурал

1994 онд Саламанкад болсон ЮНЕСКО-ийн зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын асуудлаарх олон улсын бага хурлаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд тэгш хамруулан сургахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг улс орнуудад хандан уриалж үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан гаргасан.

Монгол улсын хууль, эрх зүйн баримт бичигт оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмших талаар тусгагдсан байдал

Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он

Үндсэн хуульд хүний амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, сурч боловсрох, эвлэлдэн нэгдэх, халдашгүй чөлөөтэй байх, шашин шүтэх, эс шүтэх, итгэл үнэмшилтэй байх болон бусад эрхүүдийг баталгаажуулан хуульчилсан билээ.

Боловсролын тухай хууль, 2002он[31]

Тус хуульд “Монгол Улсын боловсролын зорилго нь бие бялдрын зохих чадавхитай, ..., бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршиж байгаа” бөгөөд “хүмүүнлэг, ардчилсан, тасралтгүй, бүх нийтэд хүртээмжтэй байх” хэмээн хуульчилсан байна. Мөн Боловсролын тухай хуульд иргэнийг сурч боловсроход хөгжлийн онцлог, эрүүл мэндээр нь ялгаварлан гадуурхахгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамран сургах нөхцөл бололцоог бүрдүүлэх үүргийг төр хүлээхээр хуульчилсан.

Боловсролын тухай хуульд **“хөгжлийн бэрхшээлтэй суралцагч”** гэж төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол, гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавхи нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс суралцах боломж нь хязгаарлагдсан суралцагчийг хэлнэ гэдгийг тодорхойлсон байна. Түүнчлэн тус хуульд нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг сургуулийн байршил, хэв шинж, мэргэжлийн чиглэл болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээтэй уялдуулан сургалтын байгууллага тус бүрээр ялгавартай тогтоох бөгөөд аргачлалыг нь боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахыг хуульчилсан.

Бага дунд боловсролын тухай хууль, 2002 он[32]

Тус хуульд ЕБС-ийн захирлын нийтлэг үүргийг тодорхойлохдоо “...хамран сургах тойргийн хүүхдийг сургуульд бүрэн хамруулж, тэдэнд суурь боловсрол заавал эзэмшүүлэх, иргэдэд нийтийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах үүрэгтэй” гэж заажээ[33].

Мөн тус хуулийн 3 дугаар бүлгийн 13 дугаар зүйлд Ерөнхий боловсролын тусгай сургуулийн зорилго, чиг үүргийг хуульчижээ[34]. Үүнд: .

[31] Тус Конвенцид Монгол Улс 1990 онд нэгдсэн

[32] Боловсролын тухай хуульд 2002 онд батлагдсанаас нь хойш нийт 10 удаа нэмэлт өөрчлөлт орсон ба хамгийн сүүлд 2011 оны 1 сард нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

[33] Боловсролын тухай хууль, 2002 он, 4 дүгээр зүйл

[34] Мөн тэнд, 3.1.9.

- Ерөнхий боловсролын тусгай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах үйлчилгээ үзүүлж, бага, суурь, бүрэн дунд боловсрол, мэргэжил эзэмшүүлэх сургалтын байгууллага мөн.
- Ерөнхий боловсролын тусгай сургуулийн хамран сургах тойрог тогтоох, аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбар бүлэг ажиллуулах, элсэлтийг зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
- Ерөнхий боловсролын бусад сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.
- Ерөнхий боловсролын тусгай сургууль нь ерөнхий боловсролын бусад сургууль, багш, иргэн, гэр бүл, олон нийтэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ.
- Тусгай сургуульд орон тооны арга зүйч, нийгмийн болон эрдэм шинжилгээний ажилтан тус тус ажиллаж болно.
- Ерөнхий боловсролын тусгай сургуульд энэ хуулийн 12.6-д заасан ажилтнаас гадна эмч ажиллана.
- Ерөнхий боловсролын тусгай сургууль нь сургалт-үйлдвэрлэлийн дадлагын газартай байж болно.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, 2008 он

Тус хуульд “Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих, сургуульд бэлтгэхэд оршино” хэмээн заажээ.[35] Мөн ”тусгай цэцэрлэг” гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллагыг хэлнэ гэж заасан байна[36]. Түүнчлэн хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болох бөгөөд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болохыг хуульчилсан[37].

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, 2002он

Тус хуулиар хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах явдлыг төр, гэр бүлийн үндсэн үүрэг байх ёстой тухай заагаад хүүхдийг үндэс угсаа, нийгмийн гарал, байдал, боловсрол, эрүүл мэндийн байдлаар ялгаварлан гадуурхахгүй, эрх тэгш байлгах тухай зарчмыг заасан байна. Түүнчлэн бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, садар самуун, хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санаанд болон бие махбодийн хохирол хүлээсэн, эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулах хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг хүнд нөхцөлд байгаа хүүхэд гэж үзнэ. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хүнд нөхцөлд байгаа хүүхдэд дараахь халамж, хөнгөлөлт, тусламж үзүүлнэ. Үүнд:

- боловсрол, мэргэжил эзэмшихэд туслалцаа үзүүлэх;
- эрүүл мэндийг нь нөхөн сэргээх, сувилах,тахир дутуу хүүхдэд хиймэл эрхтэн болон бусад хэрэгслийг үнэ төлбөргүй олгох;
- хүнд нөхцөлд байгаа хүүхдийг үрчилсэн гэр бүлд төрөөс тэтгэмж олгох;

[35] Бага дунд боловсролын тухай хуульд 2003, 2006, 2008 онуудад тус тус нэмэлт өөрчлөлт оруулжээ.

[36] Бага дунд боловсролын тухай хууль, 2002он, 20.2.8.

[37] Мөн тэнд, 3.13.

- хүүхдийг асран хамгаалах байгууллагад шилжүүлж, халамжийн үйлчилгээнд хамруулах;
- хүүхдийг сайн дурын үндсэн дээр асран хүмүүжүүлэх гэр бүлд дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөр”, 2003он

Хөгжлийн бэрхшээтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулан сургах үзэл баримтлалыг хэрэгжүүлэхийн тулд 2003 онд тус хөтөлбөрийг БСШУ-ны, ЭМ-ийн, НХХын сайдуудын хамтарсан тушаалаар батлан гаргасан байна. Уг хөтөлбөрт дараах асуудлыг дэвшүүлсэн. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургах арга зүйг боловсронгуй болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулан сургах нөхцлийг бүрдүүлсэн сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажилладаг багшийн ур чадварыг нэмэгдүүлэх.

Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 42 дугаар заалтыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрийг 2006 онд батлан хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөрийг 2006-2012 оны хугацаанд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн эрх, эрх чөлөөг хангахад тулгарч байгаа хүндрэлтэй асуудлыг төрийн ба иргэний нийгмийн байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэхэд чиглэгдэж байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль”, 2005 он[38]

2005 онд УИХ “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг батлаж, 2008 онд тус хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тогтолцооны хүрээнд төрөөс үзүүлж буй үйлчилгээнд хамрагдах боломж, үйлчилгээний цар хүрээнд тодорхой өөрчлөлт оруулсан. Тус хуулинд тусгагдсан үндсэн өөрчлөлтүүдийг дурьдвал:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тодорхойлох нэр томъёо;
- Нийгмийн халамжийн сангаас үзүүлэх тусламж, хөнгөлөлт;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн тусгай хэрэгцээт боловсролд үнэ төлбөргүй хамрагдахыг төрөөс дэмжих талаар тусгайлсан заалт;
- Олон нийтийн хэрэгцээний газруудын дэд бүтцийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай хэрэгцээнд нийцүүлэх талаарх зохицуулалт;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаарх статистик мэдээллийг цуглуулах, боловсруулах зохицуулалт.

Тус хуулийн долдугаар зүйл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурах, боловсрол эзэмших эрхийг тодруулан зохицуулсан. Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших талаарх заалтуудыг тодруулбал:

> 7.1. Сүрьеэ зэрэг архаг халдварт өвчний халдвартай үед байгаагаас бусад тохиолдолд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэн эрүүл иргэдтэй хамт сурч,

[38] Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, 2008 он, 3.1

боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй бөгөөд тэдгээрийг бүх шатны боловсрол эзэмшихэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

7.2. Бүх шатны боловсролын болон мэргэжил олгох байгууллага нь сурч, боловсрох, мэргэжил эзэмших чадвартай энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг энэ хуулийн 7.1-д зааснаас бусад үндэслэлээр элсүүлэхээс, элсэлтийн шалгалтанд оруулахаас татгалзахыг хориглоно.

7.3. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан хүүхэд энэ хуулийн 7.1-д заасан шалтгаангүй бол сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагад эрүүл хүүхэдтэй хамт хүмүүжих эрхтэй.

7.5. Тусгай хэрэгцээт боловсрол олгох ясли, цэцэрлэг, бүх шатны сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцах хүүхэд ба иргэнийг эрүүл мэндийн байгууллагын нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комисс тодорхойлно.

7.6. Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллага нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэний боломжид үндэслэн стандартын дагуу боловсрол эзэмшүүлнэ.

7.7. Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын стандартыг боловсролын болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, стандартчиллын төв байгууллагаар батлуулна.

7.8. Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд үндсэн цалингийн 10-30 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлс олгоно[39].

7.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн тусгай хэрэгцээт боловсролд үнэ төлбөргүй.

“Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр (2002-2010)”, 2002 он

Тус хөтөлбөрт нь хүүхдийн эрүүл мэнд, хоол хүнс, хөгжил, боловсрол, нийгмийн оролцоо, эрхийн хамгаалал, амьдралын орчин зэрэг олон талт асуудлыг хамарсан, нийгмийн суурь үйлчилгээг оновчтой хүргэх бодлого, үйл ажиллагааны чухал баримт бичиг хэмээн тодорхойлсон байна. Энэхүү хөтөлбөрийн нэг заалтад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд эцэг эх, хамт олон гэр бүлд түшиглэсэн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх тухай дурьджээ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ерөнхий болон мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх боломжийг өргөжүүлэх, насанд хүрсний дараа тэдний амьдралын баталгааг хангах асуудлыг судалж шийдвэрлэх талаар мөн заасан байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөр”, 2006 он

Тус дэд хөтөлбөрийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хувь хүн, нийгмийн гишүүний хувьд өөрийн сонголт, үзэл бодол, үнэт зүйлстэй байх, бие даасан аливаа үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх тэдгээрийн чадамж, чадварыг хөгжүүлэх, нийгмийн амьдралд оролцох оролцоог хөхиүлэн дэмжих орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална. Үүнд:

- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд амьдрах, эсэн мэнд хөгжих, эрхээ хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцоход шаардлагатай мэдээлэл хүртээмжтэй байх;
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд санаа бодлоо илэрхийлэх боломжтой байх;
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ялгаваргүйгээр гэр бүл, сургууль, хамт олны дунд шийдвэр гаргахад оролцохыг хүлээн зөвшөөрдөг байх;
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өөрийн болон нийгмийн сайн сайхан хөгжлийн

[39] Мөн тэнд

төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагад эвлэлдэн нэгдэх, үүсгэн байгуулахад насанд хүрэгчдийн туслалцаа, дэмжлэгийг авдаг байх зэрэг болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог хангах олон нийтийн түншлэл, хамтын ажиллагаа өргөжүүлэх зорилгоор олон үйл ажиллагааг тодорхойлсоны дотор боловсролын салбарын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх дэмжлэгийн талаар дараах арга хэмжээнүүдийг тусгажээ. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтад ногдох хувьсах зардлын норматив хэмжээг нэмэгдүүлэх, цэцэрлэг, сургуулийн багшийн ажлын үнэлгээний хэлбэрийг өөрчлөх, урамшууллыг боловсронгуй болгож шинэчлэх;
- Ердийн сургуулиас тусгай сургуульд шилжүүлдэг тогтолцоог тусгай сургуульд 3 хүртэл жил суралцаж зохих чадамж, чадварын боломжид хүрсэн сурагч ерөнхий боловсролын сургуульд шилждэг болгон өөрчлөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд тэгш хамруулан сургах бодлогыг хэрэгжүүлж, тэдгээрийн сургууль завсардалтыг бууруулах;
- “Сурагчийн өдрийн цай“ хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн витаминжуулалтын зардлыг нэмж тусгах асуудлыг судлах;
- Хүнд хэлбэрийн эмгэгтэй хүүхдийн хэрэгцээнд тулгуурлан танхимын болон гэрийн сургалт хосолсон хөтөлбөр боловсруулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй ахлах ангийн сурагчдыг гадаад хэл, компьютерийн сургалтад хамруулж, мэргэжлийн болон дээд боловсрол эзэмших боловсролын байгууллагад суралцахад нь бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд зориулсан брайл, аудио, видео ном, сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын онцлогт зориулсан бялдаржуулах буюу “Сэргээн засалт”-ын танхимыг орон нутагт байгуулах зэрэг болно.

Ийнхүү дээр авч үзсэн хууль эрх зүйн зохицуулалтын дагуу Монгол Улсын боловсролын тогтолцоо нь оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үндсэн хоёр чиглэлээр:

- Ердийн сургалттай ерөнхий боловсролын сургуульд бусад хүүхдүүдийн хамт;
- Тусгай сургалттай ерөнхий боловсролын сургуульд боловсрол эзэмших боломжийг олгодог.

Мөн Боловсролын тухай хуулиудад Ерөнхий боловсролын тусгай сургуулийн зорилго, зарчим, чиг үүргийг хуульчилж, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, оролцоог дэмжих талаархи Хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх халамж, хөнгөлөлт, тусламжийг тодорхойлж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэн тусгай хэрэгцээт боловсролд үнэ төлбөргүй суралцах, тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд үндсэн цалингийн 10-30 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлс олгохыг хуульчилжээ.

3. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох тогтолцоо, түүний шатлал

Монгол улсын албан боловсролын тогтолцоо нь оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үндсэн 2 чиглэлээр буюу ердийн сургалттай цэцэрлэг, ерөнхий боловсролын

сургуульд бусад хүүхдүүдийн хамт, тусгай сургалттай цэцэрлэг, сургуульд сургуулийн өмнөх болон бага, дунд шатны боловсрол эзэмших боломжийг олгодог.

1990 оноос өмнө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бусад хүүхдүүдээс тусгаарлан тусгай сургалттай сургуульд боловсрол эзэмшүүлэх бодлого голчилж байсан бөгөөд тус бодлогын хүрээнд 1964 онд хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан анхны тусгай сургалттай 29 дүгээр сургууль байгуулагдсан нь тусгай хэрэгцээт боловсролын эхлэл байсан.

Одоо 29 дүгээр дунд сургууль нь 21 аймаг, нийслэлийн 6 дүүргээс ирсэн 360 орчим суралцагч, 60 гаруй багштай, дотуур байртай үйл ажиллагаа явуулж байна. Энэ сургуульд одоо хэл сонсголын бэрхшээлтэй цэцэрлэгийн 2 бүлэгт 22 хүүхэд, бага ангийн 17 бүлэгт 168 хүүхэд, дунд ангийн 15 бүлэгт 158 хүүхэд, ахлах ангийн 1 бүлэгт 11 хүүхэд, цэцэрлэгийн 2 бүлэгт 22 хүүхэд боловсрол эзэмшиж байна. 2011-2012 оны хичээлийн жилд 100 хүүхдийн цэцэрлэг ашиглалтанд орно. Энэ сургуульд мэргэжлийн согог зүйч багш 16 ажиллаж байгаагаас 1 нь Унгарт, 15 нь ОХУ-ын Эрхүү, Ленинград, Москва хотуудад 1977- 2003 онд суралцаж төгссөн байна.

1967 онд тусгай сургалттай 25 дугаар сургууль байгуулагдсанаар оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэдэнд зориулагдсан хөтөлбөрөөр боловсролын үйлчилгээнд хамруулах эхлэл тавигдсан.

Цэцэрлэг, ЕБС-д хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх статистикийн мэдээллийг “СӨБ-2, БДБ-1” маягтаар БСШУЯ авдаг байна. Энэхүү мэдээллийг харах, сонсох, хэл яриа, оюун ухаан, бие эрхтний гэсэн ерөнхий үзүүлэлтийн хүрээнд хүүхдийн тоог анги, хүйсээр авч байгаа юм. Мөн энэ үзүүлэлтийг гаргах нэгдсэн аргачлал байхгүй байгаагаас харилцан зөрүүтэй мэдээлэл байгааг үгүйсгэх аргагүй юм.

Бага дунд боловсролын тухайд 2010-2011 оны хичээлийн жилийн байдлаар улсын хэмжээнд 6-22 насны 18298 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцаж байгаагаас оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй 1523 суралцагч ерөнхий боловсролын 4 тусгай сургууль болох СБД-ийн 25 дугаар дунд сургууль, БЗД-ийн 55дугаар дунд сургууль, БГД-ийн 70 дугаар дунд сургууль, болон хөдөө орон нутгийн ердийн сургалттай ЕБС-д цөөхөн тооны сурагч суралцаж байна. Үүнээс бага ангид 952, дунд ангид 553, ахлах ангид 18 сурагч суралцаж байна.[40] Нийт (1523) оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 1205 нь хотын 4 тусгай сургуульд сурч байгаа ба хөдөө орон нутаг болон бусад ердийн сургалттай ЕБС-д 318 сурагч байна.

Улаанбаатар хотын 4 дүүрэгт тус бүр нэг нэг оюун ухааны болон тархины саажилт бусад хэлбэрийн оюуны хөгжлийн бэрхшээл хавсарсан хүүхдүүдэд бага болон дунд боловсрол олгохоор дараах 4 ЕБДС үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр сургуульд 2010-2011 оны хичээлийн жилд суралцаж байгаа сурагч болон одоо багшилж байгаа багшлах боловсон хүчний тоог сургууль тус бүрээр илэрхийлье [41].

- СБД-ийн 25 дугаар дунд сургууль. 20 бүлэгт 252 сурагч сурч байгаагаас бага ангийн 12 бүлэгт 140, дунд ангийн 8 бүлэгт 112 сурагч сурч байна. Нийт 38 багштайгаас мэргэжлийн согог зүйч багш 10 байгаагийн 1 нь Унгар улсад, 9 нь Эрхүүгийн БДС-ийг 1980-1995 онд төгссөн байна.Нэг бүлэг дунджаар 10 - 15 сурагчтай.
- БГД-ийн 70 дугаар дунд сургууль. 18 бүлэгт 249 сурагч сурч байгаагаас бага

[40] Мөн тэнд

[41] Сургууль тус бүрийн захирал, сургалтын менежерээс утсаар авсан

ангийн 10 бүлэгт 129, дунд ангийн 8 бүлэгт 120 сурагч сурч байна. Нийт 32 багштайгаас 8 нь мэргэжлийн согог зүйч багш бүгд Эрхүүгийн БДС-ийг 1984-1994 онд төгсжээ. Нэг бүлэгт дунджаар 12-15 сурагчтай.

- БЗД-ийн 55 дугаар дунд сургууль. 35 бүлэгт 469 сурагч сурч байгаагаас бага ангийн 20 бүлэгт 318, дунд ангийн 15 бүлэгт 151 сурагч сурч байна. Нийт 53 багштайгаас мэргэжлийн согог зүйч багш 4, бүгд ОХУ-ын Ленинград болон Эрхүүгийн БДС-ийг 1984-1994 онд төгссөн. Нэг бүлэг дунджаар 15 - 16 сурагчтай.
- ХУД-ийн 63 дугаар дунд сургууль. 17 бүлэгт 235 сурагч сурч байгаагаас бага ангийн 9 бүлэгт 115, дунд ангийн 8 бүлэгт 120 сурагч сурч байна. Нийт 27 багштайгаас мэргэжлийн согог зүйч багш 6, бүгд Эрхүүгийн БДС-ийг 1985-1990 онд төгссөн. Нэг бүлэг дунджаар 11 - 15 сурагчтай.

Сургуулийн өмнөх боловсролын тухайд: Одоогийн байдлаар оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай цэцэрлэг байхгүй байгаа бөгөөд тархины саажилттай хүүхдийн БЗД-ийн 10 дугаар тусгай цэцэрлэгт хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хамрагдаж байна.Энэ цэцэрлэгийн 11 бүлэгт 1-5 насны нийт 136 хүүхэд, үүнээс бага ангийн 6 бүлэгт 46, дундын 2 бүлэгт 25, ахлах 1 бүлэгт 20, бэлтгэлийн 2 бүлэгт 45 хүүхдийг 9 багш, 2 туслах багш удирдан сургалт хүмүүжлийн ажил явуулж байна.

Хот хөдөөгийн зарим ердийн сургалттай цэцэрлэг, сувилалын яслийн жирийн ангид 1-5 хүртэл тооны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагддаг. Ер нь сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулах талаар Дэлхийн зөн, Японы хүүхдийг ивээх сан, БНСУ-ын Paradise, Италийн IPO зэрэг олон улсын байгуулгууд ердийн цэцэрлэгийн дотор янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээр холимог 1 анги нээж төсөл хэрэгжүүлэх замаар сургалтанд хамруулах болсон.

Хүснэгт 2

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт[42]

Хичээлийн жил	Нийт суралцагчдын тоо	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо	Нийт суралцагчдад эзлэх хувь
2006-2007	122536	1058	8.6
2007-2008	130758	1031	7.8
2008-2009	130710	988	7.5
2009-2010	142065	1156	8.1

Энэ статистик мэдээнээс харахад сургуулийн өмнөх боловсролд хамрагсдын маш бага буюу 8% -ийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эзлэж байна. Оюун ухааны хөгжлийн бэрхшээл нь ихэвчлэн 5-аас дээш насанд илэрдэг тул хэдэн хүүхэд байгаа нь тодорхой бус юм.

4. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалт, боловсролд баримтлаж байгаа стандарт

БСШУ-ы сайдын 2005 оны 387 дугаар тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын стандартыг “Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын хөтөлбөр” нэртэйгээр баталж, 2005-2006 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулиудад

[42] БСШУЯ-ны статистик мэдээ

мөрдөж байна.

Энэ хөтөлбөрөөр оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад бага боловсрол олгох тусгай хэрэгцээт боловсролын сургалтын төлөвлөгөө нь нөхөн сэргээх сургалт ба ерөнхий эрдмийн 10 хичээл- монгол хэл, математик, амьдрах ухаан, хүн орчин, дуу хөгжим, зураг, технологи, биеийн тамир , англи хэл, мэдээлэл зүй хичээлээр нийт 748-850 цагийн хичээлийг 34 долоо хоног хичээллэхээр төлөвлөсөн байна. Долоо хоногт ноогдох цаг I-III ангид 22 цаг, IV ангид 23 цаг, V ангид 25 цаг. Нэг өдрийн ачаалал I-III ангид 4,4 цаг байна, IV ангид 4,6 цаг, Y ангид 5 цаг, нэгж хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байна. Нөхөн сэргээх сургалт буюу хэл засал, хөдөлгөөн засал, ахуйн заслын ганцаарчилсан сургалтын хичээлийг мэргэжлийн багш заах бөгөөд нөхөн сэргээх сургалт шаардлагатай суралцагч бүрт 20 минутаар I, II ангид долоо хоногт 3-4 удаа, III-V ангид долоо хоногт 2-3 удаа тус тус хичээллэнэ.

Сэтгэл заслын хичээлд хамрагдах шаардлагатай суралцагчид анги удирдсан багш ганцаарчилсан сургалтыг зохион байгуулах бөгөөд 1 цагийн хичээлд 2 хүүхэд хамрагдана. Нэг суралцагч 7 хоногт 2 удаа сэтгэл заслын хичээлд хамрагдах ба сургалтын хөтөлбөрийг улирал бүрээр гаргаж, сургалтын менежер баталгаажуулсан байна. Амьдрах ухааны хичээлийг тухайн ангийн суралцагчийн нас, сэтгэл зүй, хөгжлийн бэрхшээлийн онцлог, хэлбэрийг харгалзан тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна. (Хүснэгт №1)

Дунд боловсрол олгох тусгай хэрэгцээт боловсролын сургалтын хөтөлбөр нь нөхөн сэргээх сургалт ба ерөнхий эрдмийн 14 хичээл - монгол хэл, математик, технологи, англи хэл, нийгмийн ухааны баримжаа, байгалийн шинжлэл, газарзүй, эрүүл мэнд, биеийн тамир, мэдээлэл зүй, иргэний боловсрол, биеийн тамир, дуу хөгжмийн хичээлээр нийт 945-1085 цагийн хичээлийг 35 долоо хоног хичээллэхээр төлөвлөжээ. Долоо хоногт ноогдох цаг VI ангид 27 цаг, VII ангид 28 цаг, VIII ангид 29 цаг, IX ангид 31цаг. Нэг өдрийн ачаалал VI ангид 5,4 цаг, VII ангид 5,6 цаг, VIII ангид 5,8 цаг, IX ангид 6,2 цаг байна. Нэгж хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байна.

Нөхөн сэргээх сургалт буюу хэл засал, хөдөлгөөн засал, ахуйн заслын ганцаарчилсан сургалтын хичээлийг мэргэжлийн багш заах бөгөөд нөхөн сэргээх сургалт шаардлагатай суралцагч бүрт 20 минутаар VI-IX ангид долоо хоногт 2 удаа хичээллэнэ. Сэтгэл заслын хичээлд хамрагдах шаардлагатай суралцагчид анги удирдсан багш ганцаарчилсан сургалтыг зохион байгуулах бөгөөд 1 цагийн хичээлд 2 хүүхэд хамрагдана. Нэг суралцагч 7 хоногт 2 удаа сэтгэл заслын хичээлд хамрагдах ба сургалтын хөтөлбөрийг улирал бүрээр гаргаж, сургалтын менежер баталгаажуулсан байна.

Сургуулийн материаллаг бааз, боловсон хүчний нөөцөд тулгуурлан технологийн хичээлийг VIII-IX ангид суралцагчдийн сонирхол, хөгжлийн бэрхшээлийн онцлогт тохируулан бүлгээр зохион байгуулна./ Хүснэгт №2/

Сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдэд зориулсан тусгай стандарт байхгүй бөгөөд Бага насны хүүхдийн хөгжлийн стандартад суурилсан агууллагын сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байна.

Хүснэгт 3.1

Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулийн бага боловсролын сургалтын төлөвлөгөө

Бага боловсрол

Хэлбэр	Хичээлийн нэр	Жилийн нийт цаг					Нийт цаг
		I	II	III	IV	V	

Хичээл	Монгол хэл	272	272	272	272	272	1360
	Математик	136	136	136	136	136	680
	Мэдээлэл зүй					34	34
	Англи хэл					34	34
	Амьдрах ухаан	68	68	68	68	68	340
	Хүн орчин	Хүн байгаль					408
		68	68	68	68	68	
					Эрүүл мэнд		
					34	34	
	Хөгжим	68	68	68	68	68	340
	Биеийн тамир	68	68	68	68	68	340
	Дүрслэх урлаг, технологи	68	68	68	68	68	340
Нөхөн сэргээх сургалт		Хэл засал, хөдөлгөөн засал, ахуйн засал,сэтгэл заслын ганцаарчилсан сургалт хүүхэд нэг бүрт 20 мин					
Долоо хоногт ногдох цаг		22	22	22	23	25	
Хичээлийн жилийн нийт цаг		**748**	**748**	**748**	**782**	**850**	**3876**
1 өдрийн ачаалал		4.4	4.4	4.4	4.6	5	

Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулийн суурь боловсролын сургалтын төлөвлөгөө

Суурь боловсрол **Хүснэгт 3.2**

Хэлбэр	**Хичээлийн нэр**	**Жилийн нийт цаг**				**Нийт цаг**
		VII-шилжил-тийн	**VII**	**VIII**	**IX**	

Хичээл	Монгол хэл	175	175	175	175	700
	Англи хэл	70	70	70	70	280
	Математик	105	105	105	105	420
	Иргэншил	35	35	35	35	140
	Түүх	35	35	35	35	140
	Байгалийн шинжлэл	70				70
	Газарзүй		70	70	70	210
	Эрүүл мэнд	35	35	35	35	140
	Биеийн тамир	70	70	70	70	280
	Хөгжим	35	35	35	35	140
	Технологи	140	175	210	280	805
	Мэдээлэл зүй	70	70	70	70	280
	Нийгэм ахуйн баримжаа	70	70	70	70	280
	Иргэний боловсрол	35	35	35	35	140
Нөхөн сэргээх сургалт		Хэл засал, хөдөлгөөн засал, ахуйн засал,сэтгэл заслын ганцаарчилсан сургалт хүүхэд нэг бүрт 20 мин				
Жилийн нийт ачаалал		**945**	**980**	**1015**	**1085**	**4025**
Долоо хоногт ногдох цаг		27	28	29	31	
1 өдрийн ачаалал		5.4	5.6	5.8	6.2	

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх, бэрхшээлийг тогтоох нэгдсэн аргачлал байхгүй тул “ Бага, дунд боловсролын тухай хуулийн 13.2 дахь” заалтыг үндэслэн БСШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 7 дугаар сарын 5-ний өдрийн 325 дугаар тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх арга зүй, аргачлал боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж одоо АДРА-Монгол олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд нийгмийн цогц үйлчилгээ үзүүлэх арга зүй болон Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх арга турших ажлыг Баянхонгор, Завхан, Улаанбаатар хотын 2 дүүрэгт зохион байгуулахаар бэлтгэлийг хангаж байна[43]. Мөн манай улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээний систем өнөө хүртэл төлөвшөөгүй нь ердийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургахад зарим талаар бэрхшээл учруулж байгаа юм.

Энэ нь бага, дунд боловсролын сурлагын амжилтыг үнэлэх бүхий л төрлийн шалгалт /анги дэвших болон сургууль төгсөх, Улсын мэргэжлийн хяналтын газар, аймаг нийслэлийн Боловсрол, соёлын газраас авч буй түвшин тогтоох шалгалт гэх мэт/-д хөгжлийн

[43] БСШУЯ-ны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол хариуцсан мэргэжилтний мэдээллээс

бэрхшээлтэй хүүхдийн амжилтаас шалтгаалан сургууль, ангийн сурлагын амжилт нь доогуур үнэлэгдэх тохиолдол гарч байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургууль, багш нар авч сургахаас зарим талаар татгалзахад хүргэж, улмаар тэд боловсролд тэгш хамрагдан сурах эрхээ алдахад ч хүрч байгааг үгүйсгэх аргагүй.

Эл байдалд дүгнэлт хийж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн хүүхдийн нэгэн адил арга зүйгээр үнэлж буй үнэлгээний өнөөгийн арга хэлбэрийг өөрчилж, тэдний онцлог, ялгаатай байдлыг харгалзан хөгжлийн ахицаар нь үнэлэх үнэлгээний оновчтой системийг бүрдүүлэх зорилгоор дээрхи ажлын хэсгээс “Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг судлах, үнэлэх журам”-ын төслийг боловсруулан 2010 оны 3, 7 - 8 дугаар сард Ховд, Сэлэнгэ, Улаанбаатар хотод нийт 4 хэлэлцүүлэг зохион байгуулж, 120 гаруй багш, эцэг эх, захирал, эмч, олон нийтийн байгууллагын төлөөллийн саналыг авч тусган журмын төслийг эцэслэн боловсруулж дуусгажээ.

5. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын байгууллагын багшлах боловсон хүчин, төрөөс баримтлаж байгаа бодлого

Өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа Улаанбаатар хотын 4 сургууль, 29 дүгээр сургуульд нийт 210 багш ажиллаж байгаагаас мэргэжлийн согог зүйч 45 (21,4%) багш ажиллаж байна. Эдгээр багш нар бүгд 1984-1995 онд гадаадад, тухайлбал Унгар улс болон ОХУ-ын Ленинград, Москва, Эрхүүгийн их, дээд сургуулиудад согог зүйч багшийн мэргэжлээр төгсжээ. Эндээс 1980-1990 онд жил бүр 2-3 хүнийг гадаадын их дээд сургуулиудад явуулж согог зүйч багш бэлддэг байснаа 1990 оноос хойш тасарсан нь ажиглагдаж байна.

Одоо БСШУЯ Монгол улсын Боловсролын их сургууль, АДРА олон улсын байгууллагатай хамтран МУБИС-ийн ерөнхий эрдмийн болон сэтгэл судлалын мэргэжлийн ангиудын сургалтын хөтөлбөрт тусгай хэрэгцээт боловсролын агуулгыг тусгаж, 60 цагийн хичээлийг тус сургуульд суралцаж буй бүх багшийн мэргэжлийн ангийн оюутнууд судалж байна. Өнөөдрийн байдлаар Сургуулийн өмнөх боловсролын сургууль, Багшийн сургуульд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог”- ийн талаарх бие даасан хичээлийг дээрх сургуулийн оюутнууд судалж байна.

Багш бэлтгэдэг сургуулийн багш, оюутнуудад зориулсан гарын авлага, сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй”, “Аутизмтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” зэрэг 10 гаруй ном, гарын авлагыг боловсруулан хэвлүүлж сургуулиудын номын сангуудад хүргэн оюутнууд ашиглаж байна. Монгол улсын Боловсролын Их сургуулийн Боловсрол судлалын сургуулийн дэргэд “Тэгш хамруулан сургах боловсролын төв”-ийг АДРА-Монгол олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр байгуулан ажиллуулж байна. Тус төв нь багш бэлтгэдэг сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах сонирхол бүхий оюутнуудад зориулсан сургалт, төрөл бүрийн мэдээллээр хангах үйл ажиллагааг явуулдаг байна. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах дур сонирхолтой багшийг бакалаврын дараах сургалтаар бэлтгэх нь оновчтой гэж үзэж байна.

БСШУ-ны сайдын 2010 оны тушаалаар батлагдсан Мэргэжил дээшлүүлэх кредитийн сургалтаар багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн чиглэлээр сургалт зохион байгуулах эрх олгогдож дээрх сургалтуудад хот, хөдөөгийн 1500 гаруй багш хамрагдаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйгээ дээшлүүлсэн байна.

6. Хөдөө орон нутагт амьдардаг оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролд хамрагддаг эсэх

Хөдөө орон нутагт оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ердийн цэцэрлэг,

сургуульд хамрагдаж байгаа. БСШУЯ-ны 2010-2011 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр улсын хэмжээнд 6-22 насны оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй 1523 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд сурч байна. Эдгээр хүүхдээс Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 25, 55, 63, 70 дугаар дунд сургуульд 1205 хүүхэд байгаа нь хөдөө орон нутгийн ердийн сургалттай ЕБС-д цөөхөн тооны буюу ердөө 318 сурагч суралцаж байна.

Энэ нь Улаанбаатар хотод сурч байгаа хүүхдийн тоотой харьцуулахад ихээхэн цөөхөн байгаа нь энэ төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд орон нутагт сургуульд маш бага хамрагдаж байгааг харуулж байна.Энэ нь хэд хэдэн шалтгаантай.Үүнд: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн илрүүлэлт хангалтгүй, тухайн хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг дан юм уу хавсарсан юмуу гэдгийг тогтоох нэгдсэн стандарт байхгүй, орон нутагт төрөлжсөн тусгай сургууль, тэр хүүхдүүдтэй ажиллах мэргэжлийн багш боловсон хүчин байхгүй, ном сурах бичиг, анги танхим хангалтгүй зэрэг болно.

Тус яамнаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оношлох, тэднийг ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр хичээллүүлэн хөгжлийн ахицаар үнэлэх үнэлгээний журам боловсруулан хэлэлцүүлж байгаа нь хүүхэд, эцэг эхэд ямар нэг хүндрэл дарамт учруулахгүй хүний эрхийг хүндэтгэн дээдэлсэн байхаар сайн бодож хиих, бусад салбаруудтайгаа уялдуулах хэрэгтэй байгаа юмаа.

7. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурч боловсроход улсаас зарцуулж буй төсөв

Улаанбаатар хотод улсын төсвөөс санхүүжиж буй Оюуны хөгжлийн бэрхшээлтэй тусгай цэцэрлэг байхгүй бөгөөд хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 4 цэцэрлэг, ясли (ХУД-ийн 4, СХД-ийн 41, БЗД-ийн 40, БЗД-ийн 10), 5 сургууль (ХУД-ийн 63, БГД -ийн 70, СБД-ийн 25, БЗД-ийн 55, СБД-ийн 116) үйл ажиллагаа явуулж оюуны хөгжлийн бэрхшээлтэй 19454 сурагч суралцаж байна. (мэдээллийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Нийслэлийн боловсролын газраас)

Хүснэгт 4.1

2008 оноос 2011 оны зардлын төсөв (сургууль)

д/д	Оноор	ХУД 63	БГД 70	СБД 25	БЗД 55	СБД 116	Нийт
1	2008 онд	269 446	275673,5	310083,4	430850,8		1 286056,7
2	2009 онд	255049,2	239860,5	317214,9	434176,6	286397,8	2423653,2
3	2010 онд	282680,7	243871,1	390954,6	492363,3	278156,2	2702623,7
4	2011 онд	267949,3	227627	318823,2	453661,7	286397,8	2445413,2

Хүснэгт 4.2

2008 оноос 2011 оны зардлын төсөв (цэцэрлэг)

д/д	Оноор	ХУД 4	СХД 41	БЗД 40	БЗД 10	Нийт

1	2008 онд	119961,6	104184	133055	190965,5	548166,1
2	2009 онд	115287	92353,2	130651,2	180956,4	519247,8
3	2010 онд	150722,6	108828,7	158913,3	224391,8	642856,4
4	2011 онд	179644,6	160873	201667,5	214872,5	737057,6

2011 оны улсын төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах орчныг бүрдүүлэх зорилгоор 400,0 сая төгрөгийг улсын төсөвт тусгасан бөгөөд уг санхүүжилтээр СБД-ийн 116-р сургуулийн бие засах газар, зам талбайг бэрхшээлийнх нь онцлогт нийцүүлэн засварлах ажлыг зохион байгуулна гэжээ. Мөн тус сургуулийн сантехникийн иж бүрэн засварт 70,0 сая төгрөгийг төсөвлөсөн.

2008 оноос хойш үндсэн цалингийн доод хэмжээ, суурь үнийн өөрчлөлт тодорхой хувиар нэмэгдсэн ч сургууль, цэцэрлэгийн төсвийн санхүүжилт төдийлөн хангалттай нэмэгдээгүй байна. Тусгай сургалттай сургуулиудын жилийн төсвийн санхүүжилтийг СБД-ийн 25 дугаар дунд сургуулиар жишээ болгон төлөөлүүлэн үзүүлэв:

Жилийн нийт төсвийн 60 хувь нь багш ажилтан нарын цалинд, 40 хувь нь бусад хувьсах болон тогтмол зардлуудад зарцуулагддаг.

Тусгай сургалттай СБД-ийн 25 дугаар дунд сургуулийн 2011 оны төсвийн санхүүжилт:

Тус дунд сургууль 20 бүлэгт 252 суралцагч, 56 багш, ажилтантайгаар үйл ажиллагаа явуулдаг.

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 229 355 900
- Ажил олгогчоос НДШ 25 229 200
- Үдийн цай хөтөлбөр 11 779 100
- Бичиг хэрэг 176 800
- Гэрэл цахилгаанд 4000 000
- Түлш халаалт 15 000 000
- Тээвэр шатахуунд 750 000
- Шуудан холбоонд 176 800
- Цэвэр,бохир ус 5 500 000
- Ном хэвлэл авах 147 300
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 702 200
- Эд хогшил худалдан авах 226 400
- Нормын хувцас зөөлөн эдлэл 589 300
- Эм авах 58 900
- Урсгал засварт 439 200
- Биеийн тамирын уралдаан, тэмцээнд 147 300
- Төлбөр хураамж болон бусад зардалд 1 004 600
- Нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 23 392 900
- Нийт төсвийн санхүүжилт: 318 823 200

Хувьсах зардалыг тооцохдоо Засгийн газрын 2010 оны 342 тоот “Зардлын дундаж

норматив батлах тухай” тогтоолын дагуу нэг хүүхдэд ногдох хувьсах зардал, бусад хувьсах зардлын дундаж нормативаар, Сангийн сайдын 2007 оны 8 дугаар сарын 31-ний 306/237 тоот “Итгэлцүүр батлах тухай” тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээг тооцох итгэлцүүрийг 1,07-оор нэмэгдүүлэн тооцохоор батлагдсаны дагуу санхүүждэг байна.

Бага дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13,3 дахь хэсэгт “Ерөнхий боловсролын бусад сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй” хэмээн заасан. Мөн Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “Бололовсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдалын шаардлагыг хангасан байна” гэж заасан байдаг.

Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох орчин нөхцөл бүрдүүлэх эрхийг хэрэгжүүлэх боломж олгож байгаа хэдий ч төрөөс олгож буй санхүүжилт, төсвийн хэмжээг хархад бүтэн жилийн урсгал засварт 439200 төгрөг, ном хэвлэл авах зардалд 147 300 төгрөг, эд хогшил худалдан авхад 226 400 төгрөг төсвөлсөн байгаа нь сургуулиудын ном сурах бичиг тусгай хэрэгцээг хангахад хангалттай төсөв биш юм. Иймд төсвийн хүрээнд тусгай сургуулиудын багтаамжийг өргөтгөх, тусгай тохижилтыг сайжруулах, уншлагын болон соёл урлагийн танхим, тэргэнцэртэй хүүхэд орох багтаамжтай ариун цэврийн өрөөтэй болгох зэрэг наад захын арга хэмжээг авах санхүүжилтийг нэмэгдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг идэвхтэй суралцаж амьдрах бололцоог хангах шаардлагатай байна.

Сүүлийн 3 жилд бүх мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагсдын сургалтын зардал (2008 онд Засгийн газраас нэг суралцагчид ногдох зардлыг 465-495 мянган төгрөгөөр баталсан), тэтгэлэг (сард 45 мянга, жилд 450 мянган төгрөг)-ийг төрөөс санхүүжүүлэх болсноор мэргэжлийн сургалт үйлдвэрийн төв байгуулах, иргэдийн суралцах сонирхол нэмэгдэх хөшүүрэг болсон. Тусгай сургуулиуд дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусгайлан зориулсан мэргэжлийн чиг баримжаа олгох (оёдол, эсгүүр, гар хивсчин, мужаан, үсчин) сургалтууд явагдаж байна.

Боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7,4-т “Дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг элсүүлэх хөнгөлттэй нөхцөл бүрдүүлж, тэнцсэн тохиолдолд тухайн иргэний, түүнчлэн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг сурагч буюу оюутны сургалтын зардалыг төрийн сан хариуцна” гэж заасан. Энэ заалтын дагуу сургалтын зардалыг төр хариуцсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай мэдээлэл одоогоор алга байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгаалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа хөнгөлөх” гэж заасан. Энэ заалтын дагуу унааны зардалыг хөнгөлсөн мэдээлэл мөн алга байна.

8. Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш, сурган хүмүүжүүлэгч нарын цалин, орлого

СБД-ийн 116 дугаар дунд сургуулийн захирлын 2011 оны 02 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан багш ажилтан нарын цалингийн хэмжээ: (төлөөлүүлэн түүвэрлэн үзүүлэв)

Хүснэгт 5

Албан тушаал	Албан томилолтын зэрэглэл	Ажилласан жил	Үндсэн цалин	Тусгай сургуулийн нэмэгдэл	Мэргэжлийн зэргийн нэмэгдэл	Анги даалт	Заах аргын нэмэгдэл	Сарын нэмэгдсэн цалин шимтгэл тооцоогүй
Багш	ТҮБД4-II	6	301440	90432		30144		391872
Багш	ТҮБД4-IV	17	328502	98551	32850	32850		459903
Багш	ТҮБД4-V	38	350157	105047	35016	35016	17508	490220
Багш	ТҮБД4-I	1	298428	89528		29843		387958
Асрагч багш	ТҮ 2-III	14	201477	60443				261920
Асрагч багш	ТҮ 2-I	2	194526	58358				252884

Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 162 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгаалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7,8 дахь хэсэгт заасны дагуу цалингийн хэмжээг “Тусгай хэрэгцээт боловсрол олгох төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан сургалтын байгууллагын арга зүйч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, согог зүйч, багш эмч, сувилагч, асрагч, багш, сурган хүмүүжүүлэгч, дотуур байрны хүмүүжүүлэгчид үндсэн цалингийн 30 хүртэл хувиар, Захирал, цэцэрлэгийн эрхлэгч, сургалтын менежер, сургалтын үйл ажиллагааг шууд гардан зохион байгуулдаг инженер техникийн болон үйлчилгээний албан хаагчдад үндсэн цалингийн 20 хүртэл хувиар, захиргаа гүйцэтгэх болон үйлчилгээний албан хаагчдад үндсэн цалингийн 10 хүртэл хувиар” нэмж тооцдог.

Тусгай дунд сургуулийн багш нар албан томилолтын зэрэглэлээр Багш нар ТҮБД, Хүмүүжүүлэгч багш ТҮБД3, Асрагч багш ТҮ- ний сүлжээ цалингаар ажилласан жил, мэргэжлийн зэргийн нэмэгдэл, тусгай сургуулийн нэмэгдлээ нэмж тооцоод 490220-252884 төгрөгийн (шимтгэл тооцоогүй) цалин авдаг. Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад анхаарал халамж арчилгаа, илүү цагаар ажиллах шаардлагатай ч нэмэгдэл хөлс төдийлөн хангалттай биш учраас эдгээр хүүхэдтэй багш нар ажиллах дургүй төдийгүй эмч хүртэл зайлсхийдэг байна.
Иймд оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хэрэгцээ шаардлагад тохирохуйц харилцах ур чадвартай, тэдний онцлог хэрэгцээг ойлгодог, тулж дэмжих, анхаарал халамж тавих, ёс суртахууны боловсролтой боловсон хүчин бэлтгэх сургалт арга зүйн төв бий болгож, багш нарын цалин хөлсний урамшуулалын системийг боловсронгуй болгон нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна.